

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИТХ, ЗДТГ-ЫН 2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 4 дүгээр хуралдаанаар:

- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
- Хөрөнгө акталж, дуудлага худалдаа зохион байгуулах /Өлзийт сумын ЗДТГ-ын автомашин /
- Үндсэн хөрөнгө бүртгэх, зөвшөөрөл олгох тухай
- Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулах тухай ГХБХБГ-ын 2018 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2019 онд дэвшүүлсэн зорилтын сонсгол мэдээллийг хэлэлцлээ.
- 2019.03.11-12-нд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”- үүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сум, байгууллагуудын Эрх бүхий албан тушаалтнуудын хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготойгоор аймгийн ИТХ, Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтсүүд хамтран эрх бүхий албан тушаалтнууд, 15 сумын ИТХ-ын нарийн бичиг, ЗДТГ-ын дарга, хүний нөөцийн ажилтнуудад 2 өдрийн "ЭРХ ЗҮЙН" болон "ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, ХОЛБОГДОХ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ" тухай сургалтыг зохион байгуулж, арга зүйн зөвөлгөө өгч ажиллаа.
- 2019.03.25-нд Дундговь аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулсан гэр бүлийн өдөрлөгийн үеэр Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа О.Амарсанаа "ЦЭРГИЙН ХҮНДЭТ" медалиар шагнагдсан цагдаагийн албан хаагчийн шагналыг гардуулан өгч ИТХ-аас цагдаагийн 2 албан хаагчийг шагнаж урамшууллаа.
- 2019 оны нэгдүгээр улиралд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 5 удаа хуралдаж ахмадад ээлтэй байгууллага шалгаруулж, олон улс, улс, бүсийн тэмцээнд амжилт гаргасан багш сурагчид, нутгийн уугуул суугуул иргэдийг шагнаж урамшуулах, аймгийн Засаг даргын шагналаар шагнах, аймгийн аварга малчин, тариаланч шалгаруулах, тусламж дэмжлэг үзүүлэх тухай, хөрөнгө гаргах, И-Оффис системийн байнгын ажиллагааг хангах, Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулах зардал, Шилдэг төрийн албан хаагчид шагнаж урамшуулах тухай нийт 37 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна.
- Мөн Эрдэнэдалай сум, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2018 оны өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тайлантай танилцаж ажил сайжлуулах талаар тэмдэглэлээр үүрэг өгөөд байна.
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу ISO9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоог Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжүүлэхээр, аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, Зөвлөх байгууллага Юнайтед Менежмент Консалтинг ХХК, дэмжин хамтран ажиллагч Мерит төслийн багийнхан өнөөдөр хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажлын нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулж Канадын МЕРИТ төслийн захирал Женнифер Адамс, хүний нөөцийн зөвлөх Рибекка Чалмерс, Юнайтед Менежмент Консалтинг ХХК-ны гүйцэтгэх захирал Д.Ерөө зөвлөх, тэргүүлэх аудитор Б. Гэрэл, аймгийн ЗДТГ-ын нийт албан хаагчид, хэлтэс, газар,

агентлагийн удирдлагууд, сумдын ИТХ-ын нарийн бичиг, Тамгын газрын дарга нар оролцсон байна.

- Монгол Улсын Гавьяат жүжигчин, Зууны манлай, Алдарт уртын дуучин Ж.Дорждагвын мэндэлсний 115 жилийн ой 2019 онд тохиохтой холбогдуулан, “3000 уртын дуучид, морин хуурчид”-ын наадам зохион байгуулах комиссыг томилон Монгол ардын уртын дуу “Уяхан замбуу тивийн наран”, “Энх мэндийн баяр”, “Эр бор харцага”, “Зээргэнтний шил” болон “Дундговийн магтаал”, морин хуурын аялгуу “Үүлэн бор”, “Монгол аялгуу”, “Миний нутгийн бараа”, “Төв Халх жонон”, “Дундговийн магтаал”-ыг нийт иргэддээ зааж сургах ажлыг өрнүүлэн, хуурчдыг морин хуураар хангахад санаачилга гарган ажиллахыг сумдын Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болголоо
- Нэг цэгийн үйлчилгээгээр 3 дугаар сард 3420 иргэнд цахимаар болон биечлэн лавлагаа, бүртгэлийн үйлчилгээг үзүүлж ажилласан байна.
- Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын дарга, сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар улсын удирдах ажилтны зөвлөгөөнд, аймгийн ЗДТГ-ын дарга, ТЗУХ-ийн дарга, сумдын ЗДТГ-ын дарга нар Удирдлагын академийн Төрийн албаны шинэ хууль холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлийн сургалтанд тус тус хамрагдлаа.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Татварын орлого	6,124,704,2	7,126,512,8	116,3%
2	Төсвийн гүйцэтгэл	12,851,034,7	11,260,666,82	87,6%

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Өглөг	269,398,1	383,419,0
2	Авлага	207,854,1	234,640,9

- ИТМ-2019- Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчилах төслийн арга хэмжээг гүйцэтгүүлэхээр Говийн шуранхай аялал жуулчлалын холбоотой 3 дугаар сарын 14-нд 5 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, арга хэмжээг гүйцэтгүүлэхээр Оюуны гэгээ ТББ-тай 3 дугаар сарын 4-нд 3,9 сая төгрөгийн гэрээ байгуулсан.
- Хот тохижуулах ОНӨААТҮГ-н албан хэрэгцээнд авто машин нийлүүлэх ажлын тендерт шалгарсан “Түшигмандал” ХХК-тай гэрээ байгуулсан
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Өлзийт сумын ЭМТөвийн барилгын их засвар, Говь-Угтаал сумын Спорт заалын барилга, аймгийн төвийн хатуу хучилттай 2,8 км авто зам, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Адаацаг сумын ЕБС-ийн талбайн тохижилт, багийн Засаг дарга, Цагдаа, Байгаль хамгаалагч нарын албан хэрэгцээнд мотоцикль нийлүүлэх, Мандалговь хотын гэр хорооллын ус түгээх 14 худгуудыг смарт болгох тоног төхөөрөмж нийлүүлэх, Луус сумын ЕБС-ийн дээврийн засварын ажлуудын үнэлгээний хороо байгуулагдан, Адаацаг сумын ЕБС-н талбайн тохижилт, багийн Засаг дарга, Цагдаа, Байгаль хамгаалагч нарын албан хэрэгцээнд мотоцикль нийлүүлэх, Мандалговь хотын гэр хорооллын ус түгээх 14 худгуудыг смарт болгох тоног төхөөрөмж нийлүүлэх, Адаацаг сумын ЗДТГ-н их засварын ажлуудийн тендерийг зарласан.
- Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдөр нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж Сайнцагаан сумын Билгэх үнээний байрыг 575,000 төгрөгөөр, Дэрэн сумын ЕБС-ийн УАЗ-Пургон автомашиныг 1,000,000 төгрөгөөр, Сайнцагаан сумын ЭМТөвийн УАЗ -315122 маркын автомашиныг 4,000,000 төгрөгөөр,

Приус-10 маркын автомашиныг 3,000,000 төгрөгөөр худалдаж орон нутгийн орлогод 8,575,000 төгрөгийг төвлөрүүллээ.

- Дундговь аймгийн 1991-1996 онд хувьчлагдсан аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуйн мал, эд хөрөнгийн судалгааг Дундговь дахь Төрийн архивт хадгалагдаж буй 132 хадгаламжийн нэгж бүхий өмч хувьчлалтай холбогдолтой материалаас нэгтгэн гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэв.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сум, хэлтэс, агентлагуудын Эрх бүхий албан тушаалтнууд буюу Эрх зүйн хөтөч багийн ахлагч нарыг чадавхжуулах эрх зүйн сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд 18 төрлийн хууль тогтоомжууд болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах сэдвүүдээр зохион байгуулав. Эдгээр сургалтын мөрөө Говь-Угтаал, Өлзийт, Сайнцагаан, Өндөршил зэрэг сумд аймгийн Засаг даргаас уриалсан “Авлигагүй, шударга нийгмийн төлөө хамтдаа” уриалгад нэгдэх арга хэмжээг сум, орон нутагтаа үе шаттайгаар зохион байгуулж байна.
- Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ээс ЕБС-ийн Насан туршийн боловсролын багш нарыг “Эрх зүйн хөтөч”-өөр бэлтгэх анхан шатны, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 2 агентлагт эрх зүйн албан бус сургалтыг тус тус зохион байгууллаа.
- Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Аюулгүй ухаалаг бараа, бүтээгдэхүүн” аяныг аймгийн хэмжээнд 2019 оны 3 дугаар сарын 1-нээс 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрүүдэд зохион байгууллаа.
- 2019 оны Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлэгдсэн эрх зүйн актуудыг Аюулаас сэргийлэх цогцолбор FM107,5 болон олон нийтийн цахим сүлжээгээр сурталчиллаа.
- Аймгийн Засаг даргаас 3 дугаар сард батлан гаргасан захирамжуудаас нийт 35 захирамжийг www.dundgovi.gov.mn аймгийн сайтад ил тод байршуулан сурталчилж, сумдын Засаг даргаас 2019 оны 1 дүгээр улиралд батлан гаргасан нийт 451 эрх зүйн актыг хянаж, зөвлөмж хүргүүллээ.
- Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаагаар 44 төлбөр, тэтгэлэгийн 198511,8,0 мянган төгрөгийн гүйцэтгэх баримт бичигт ажиллагааг зохион байгуулан, 9 иргэний санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэртэй 20,5 сая төгрөгийн 38 хүн, хуулийн этгээдийн төлбөр, тэтгэлгийг төлүүлсэн. Мөн торгох ялтай 5 ялтны 4190,0 мянган төгрөгийг барагдуулан орон нутгийн орлогод 1,676,0 мянган төгрөгийн төвлөрүүлэн ажилласан байна.
- Цагдаагийн газраас хэсгийн алба хаагчдын нэгдүгээр улирлын цугларалт сургалтыг зохион байгуулж аймгийн ГБХЗХГ, ТХДЖТ-тай хамтран “Хайрын дархлаа” ТББ-ын тэргүүн Т.Бямбатогтохоор “Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх”, “Эрсдэлийг хамтдаа даван туулах сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” зорилгоор “Бүх хайраа гэр бүлдээ” лекц сургалтыг зохион байгууллаа.
- Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жил болгон зарласантай холбогдуулан Улсын бүртгэлийн хэлтсээс төвийн албан хаагчдын дунд “Бүртгэгч би- Иргэн таны төлөө” 10 хоногийн аяныг зохион байгуулж УБХ-ийн албан хаагчид хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, шинэчлэн батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хууль, багц хуулиудыг судалж эзэмших, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, эрхэлсэн ажилдаа шинэ санал санаачилга нэвтрүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэн, хууль эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх, иргэний

бичиг баримтдаа хандах хандлага, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зөвлөн туслаж үйлчилгээ үзүүллээ.

Гэмт хэрэг, зөрчлийн талаархи мэдээлэл:

- Аймгийн хэмжээнд 3 дугаар сард 60 гэмт хэрэг үйлдэгдсэн нь , өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1 буюу 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 37,5 хувь, залилах гэмт хэрэг 20 хувь, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25 хувиар тус тус буурч, зөрчлийн хуулиар 4309 хүнд арга хэмжээ авсан байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Нэг хором” арга хэмжээнд аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн багш, ажилчид оюутнуудад яриа таниулга хийж, Хулд, Өндөршил, Луус сумдын Цагдаагийн хэсгийн алба хаагчид хариуцсан сумынхаа иргэд, олон нийтэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, тус аянд нэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулав.

Архивын ажлын мэдээлэл:

- Архивын Ерөнхий газраас 2019 онд зохион байгуулах сургалтанд сум, байгууллагын 35 архив, бичиг хэргийн ажилтнуудын судалгааг үндэслэн 3 ажилтныг анхан болон мэргэшүүлэх сургалтанд хамрууллаа.
- Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд 3 хөмрөг үүсгэгч байгууллагын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж 3 хөмрөгийн 96 хадгаламжийн нэгжийн 5860 хуудас баримтыг цахимд оруулсан.
- Архивын баримтын цахимжуулалтын дэлгэрэнгүй мэдээг нарийвчлалтай гарган, сарын нэгдсэн мэдээг Архивын ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж байна.
- Төрийн архивын сан хөмрөгт байгаа баримтаар 27 иргэнд лавлагаа, хуулбар хувь олгож, 15 иргэнд цахим сангаас хуулбар хувь гаргаж үйлчилсэн. 3 дугаар сард лавлагаанд давхардсан тоогоор 410 гаруй хадгаламжийн нэгж баримт ашиглуулсан.
- Төрийн архивт баримтын нөхөн бүрдүүлэлт хийх төлөвлөгөө графикайн дагуу 4 хөмрөгийн 146 хадгаламжийн нэгж баримтыг архивт хүлээн авч, заагуур заагчийг шинэчилэн, шинээр баригдсан барилга, барилгын засвар өргөтгөлийн холбогдох зураг төсөл, техник технологийн баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлсэн.
- Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журмын дагуу 2017 оны төрийн архив болон төрийн архивт хөмрөг үүсгэгч сум, байгууллагын баримтын мэдээг хөмрөг тус бүрээр гаргуулан авч тоо бүртгэлийн програмд 109 хөмрөгийг шивж оруулан нэгдсэн тайлан мэдээг цаасаар гаргаж архивлаж, мэдээг АЕГ-т албан бичгээр хүргүүлэв. Үүнд: 1920-2017 оны цаасан суурьтай 96477 хадгаламжийн нэгж, тусгай төрлийн 50 хадгаламжийн нэгж, нийт 96527 хадгаламжийн нэгж бүртгэж, програмд бүрэн оруулсан.
- Аймгийн архивын дэргэдэх ББНШАЗКомиссын хурлаар 6 хөмрөг үүсгэгч байгууллагуудын 18 данс, бүртгэл, жагсаалт, арга зүйн баримт бичгүүдийг хянан хэлэлцэж батлах ажлыг зохион байгуулсан.
- Архивын 1, 2 дугаар хадгаламжийн сангийн 90м2 талбайд шавьж устгал болон халдваргүйжүүлэх ариутгал хийлгэх талаар “Сайн түшиг” ХХК-тай ярилцаж, 4 дүгээр сард хийлгээр тохиролцов.
- Баримтын хадгалалт хамгаалалтын нөхцлийг сайжруулан, төрийн архивын хадгаламжийн сангийн цонхны гадна хамгаалалтын 6 төмөр хаалт хийж, 2 нягтруулсан шүүгээнд 3350 гаруй ХН-ийг зөөвөрлөн байршуулж , зориулалтын галын хор , дохиоллын систем суурилуулах зэрэг ажлуудыг шинээр хийсэн байна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Боловсролын чиглэлээр:

- Ирээдүйн өндөр мэдлэгтэй физикч болон инженер техникийн мэргэжилтэн болох хүсэл сонирхолтой сурагчдын авьяасыг хөгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит өмнөд бүсийн аймгуудын физикийн анхдугаар олимпиадыг Улсын физикийн хороо, МУИС-ын зөвлөх багш нартай хамтран багш, сурагчдын дунд зохион байгуулж Төв, Өмнөговь, ГовьСүмбэр аймгуудын 7-12 дугаар ангийн 200 гаруй сурагч, 21 багш оролцлоо.
- Элсэлтийн ерөнхий шалгалтын “Монгол хэл бичиг”-ийн шалгалтыг зохион байгуулж, 146 сурагчийг хамрууллаа.
- Мөн аймгийн төрөлжсөн олимпиадын газарзүй, биологи, нийгмийн тухай мэдлэг, түүх, монгол хэл, монгол бичиг, англи хэл, математик, хими, технологийн олимпиадуудыг зохион байгууллаа.
- Боловсролын үнэлгээний төвөөс чанарын үнэлгээний шалгалтыг орон даяар зохион байгуулж 18 сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдаас монгол хэл, математик, физик ба англи хэлний хичээлүүдээр шалгалт авч, “Эрдмийн далай” цогцолбор сургууль, Мандал, Гурвансайхан сумын сургуулиудаас 3 дугаар ангийн математик, монгол хэл, хүн орчин, хөгжим, 10 дугаар ангийн математик I, математик II ба монгол хэл, газарзүй, биологийн хичээлүүдээр шалгалтыг зохион байгууллаа.
- Туслах багш нарын мэргэжил дээшлүүлэх 3 кредитийн сургалтыг багшийн мэргэжил дээшлүүлэх институтын дэргэдэх “Сэтгэлийн оньс” төвтэй хамтран зохион байгуулж, 19 цэцэрлэгийн 68 туслах багшийг хамруулж, тэдний мэдлэг, ур чадварыг нь дээшлүүллээ.
- Насан туршийн боловсролын багш нарт “Бүх нийтийн эрх зүйн боловсрол”-ын сургалтыг аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар хамтран зохион байгууллаа.

Нийгмийн хамгааллын чиглэлээр:

- Аймгийн Ахмадын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж “Ахмадад ээлтэй байгууллага”-ыг шалгаруулахад Сайнцагаан сумын 3-р цэцэрлэг, Луус сумын ЕБС, Эрдэнэдалай сумын цэцэрлэгүүд шалгарч тус бүр “Батламж”, 200000 төгрөгөөр шагнагдлаа.
- Гурвансайхан сумын нутагт үйл ажиллагаа эрхэлдэг “Үнэн Бэх” ХХК-тай хамтран “Нээлттэй ажлын байрны өдөрлөг”-ийг зохион байгуулж, уурхайд 46 иргэнийг бүртгэж, байнгын ажлын байранд зуучиллаа.
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардагатай 27 өрхийн 60 иргэнд “Цахим мэдээлэл”-ийг сурталчлах ажлыг зохион байгууллаа.
- “Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зохион байгуулах нөхцөлийг сайжруулах” сургалт, хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ, ХХҮГ, ГБХЗХГ, ХХААГ, Татвар, МСҮТ, Ахмад зөвлөх, Түншлэгчид, Говийн бүсийн арга зүйн төв зэрэг байгууллагуудын нийт 40 хүнийг хамруулан зохион байгууллаа.
- Сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд “Хөдөлмөр эрхлэлтийн ажилтнуудыг чадавхижуулах” сургалтыг зохион байгуулан, мэдлэг, ур чадварыг нь дээшлүүллээ.
- “Техник мэргэжлийн боловсрол сургалтын салбарыг дэмжих-1” төсөл болон Монголын ажил олгогч эздийн холбоотой хамтран “Орон нутгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг

эрчимжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, орон нутгийн удирдлагууд, ажил олгогч, мэргэжлийн холбоодын төлөөлөл нийт 30 хүнийг оролцуулаад байна.

- Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын сантехникийн мэргэжлийн багш нарын Улсын анхдугаар уралдаанд "Барилгын сантехникч" мэргэжлийн багш Б.Цэрэнчунт 2-р байранд, Говийн бүсийн мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын шилдэг илтгэл, шилдэг заах аргач багш шалгаруулах уралдаан, спортын тэмцээнд МСҮТ амжилттай оролцож багийн дүнгээр 2-р байранд шалгарлаа.
- БНСУ-д гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг зохион байгуулж, бүртгэлд 35 хүн бүртгүүлсэнээс 5 эмэгтэй 30 эрэгтэй хамрагдлаа.
- МСҮТ-ийг сумдад төлөөлөн ажиллах ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ-өөр сумдын Насан туршийн боловсролын багш нарыг сонгон, цаашид хамтран ажиллахаар шийдвэрлээд байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

- Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, 2 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2018 онд хийгдсэн ажил, 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын чиглэлд хяналт үнэлгээ хийж заавар зөвлөмж өглөө.
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /2017-2020/ төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүсийн уулзалтанд холбогдох албан тушаалтнуудыг хамруулаад байна..
- Бөөр хамгаалах дэлхийн өдрийг тохиолдуулан “Бөөрөө хамгаалъя” сэдвээр Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгаас нээлттэй мэдээллийн өдөрлөгийг зохион байгуулж 110 үйлчлүүлэгч оролцож бөөрний өвчлөл, бөөрний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтад хамрагдан 85 үйлчлүүлэгчийн артерийн даралт, цусанд глюкоз тодорхойлж зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.
- Улаанбурхан өвчний эмнэлзүй, Лабораторийн сорьц зөв цуглуулах сэдвээр аймгуудын эмч нарт цахим сургалт зохион байгуулж хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, халдвар судлагч, хүүхдийн эмч, өрхийн эмч, халдвартын эмч нарыг, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулан “Эмнэлгийн мэргэжилтний харьцаа, хандлага, эрх зүй” сэдэвт сургалтанд нийт 75 эмч, мэргэжилтнүүд хамруулан, Пневмококкын эсрэг вакцин болон халдварт саагийн эсрэг идвэхгүйжүүлсэн вакцин нэвтрүүлэх сургалтыг ХӨСҮТ-тэй хамтран зохион байгууллаа.
- Аймгийн ЭМСалбарын удирдах ажилтны зөвөлгөөнийг “Иргэн төвтэй Эрүүл мэндийн үйлчилгээ” уриан дор зохион байгуулж, Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Зооноз өвчин судлалын төв, 15 сум, 2 өрхийн эрүүл мэндийн төвүүд болон хувийн хэвшлийн эмнэлгийн дарга удирдлагуудыг хамрууллаа.
- Улсын төсвийн санхүүжилтээр төрөлжсөн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах 7 эмч, 2 сувилагчийг шалгалтад оролцуулан, шинэ нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх сургалт судалгааны төвтэй хамтран “Анагаах ухааны эрх зүй” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад төв, хөдөөгийн нийт 110 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, ёс зүй, харилцаа хандлагын мэдлэгээ дээшлүүлээд байна.
- Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Монгол улсын “Хүний гавъяат эмч” Б.Ганхөлөгийн нэрэмжит эрдэм шинжилгээ онол практикийн 6 дахь удаагийн бага хуралд төв хөдөөгийн эмч, эмнэлгийн дээд мэргэжилтэн нийт 11 илтгэгч оролцон илтгэл тавьж, тэргүүн байрыг Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч Э.Энхзоригт “Мухар олгойн эмчилгээ, оношлогооны стандартын хэрэгжилтэнд хийсэн судалгаа” сэдвээр, Дэд байрыг Нэгдсэн эмнэлгийн эм зүйч А.Үүрийнцолмон “Дундговь аймгийн эмийн гаж нөлөөний бүртгэл үнэлгээг говийн бүсийн аймгуудтай харьцуулсан судалгаа” сэдвээр тус тус шалгарлаа.

- Дэлхийн эмч нарын өдрөөр хамт олноо хошуучсан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс Эрүүл мэндийн яамны “Эрүүлийг хамгаалахын Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 1, Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-ээр 5, Аймгийн эрүүл мэндийн салбарын “Шилдэг төрийн албан хаагч”-аар 2, Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр-3, Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 3 хүнийг шагнаж урамшуулсан байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Газар тариалангийн чиглэлээр:

- Аймгийн ИТХ-аар “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” аймгийн хөтөлбөрийн боловсруулан хэлэлцүүлээ.
- Тариалан эрхлэгчдийн сангаас жимс жимсгэний суулгац авах, болон тоног төхөөрөмж, хүлэмж авах хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж хоршоодын судалгааг авч хүргүүлээ.
- Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа тариаланч иргэдийн судалгааг гарган ХХААХҮЯамны ГТБХЗГ-т хүргүүлээ.

МАН-н салбарын хүрээнд:

- Өндөршилийн адууны омог, Сайнцагаан сумын хонины омог батлуулах МАН-н эрдэмтдийн салбар зөвлөлд судалгааны ажлаа танилцуулж 100 хувийн саналаар их эрдэмтдийн зөвлөлд оруулахаар боллоо.
- НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага /FAO/-ын хөрөнгө оруулалттай “Уур амьсгалд дасан зохицсон ухаалаг мал аж ахуй”-г хөгжүүлэх төслийг Луус суманд хэрэгжүүлэхээр болж, орон нутагт 230,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн баруун бүсийн 3 сум бэлчээрийн мал аж ахуй, бэлчээр хамгаалал чиглэлээр томоохон хөрөнгө оруулалт хийгдэхээр болоод байна.
- ХХААХҮЯ-аас 2019 онд усны геофизикийн хайгуулаар Дундговь аймагт нийт 40 цэгт хайгуулын ажил хийгдэхээр боллоо.
- Мал эмнэлгийн мэргэжилтний “Малчинд ойрхон мал эмнэлэг” нэгдсэн зөвлөгөөнд сумдын МЭТ, МЭҮН-ийн эмч мэргэжилтнүүд нийт 81 хүн оролцлоо. Уг зөвлөгөөнөөр Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг өөрийн аймагт хэрэгжүүлэх мал амьтны гоц халдарт өвчнөөс урьдчилан сэргийлэх мал амьтны шилжилт хөдөлгөөн мал мах, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавих, тэдгээрийн гарал үүслийн бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх талаар хэлэлцлээ. Зөвлөгөөний талаар МОНЦАМЭ агентлагаар дамжуулан иргэд олон нийтэд хүргээд байна.
- Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх 500,000 тун, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх 15,000 тун вакциныг татан авч сумдын мал эмнэлгийн тасагт хуваарилан 4 дүгээр сарын 1 нээс тарилгын ажил хийгдэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.
- Өвчний мэдээ тайлан, цахим, бүртгэл, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн “ArcGIS” буюу газарзүйн мэдээллийн систэмийн сургалтанд 7 хоног хамрагдлаа.

Жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн ХХААХҮЯамны сайд Ч.Улаан Дундговь аймагт ажиллах үеэр Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт орсон Шилийн Хурд ХХК, Ноён Шанхай ХХК нарын төсөл, Галтай зэт ХХК, Мандалговь хүнс ХХК, ТЭББЭ ХХК нарын үйлдвэрлэлтэй танилцууллаа.
- 3-р сарын 14-нд ХХААХҮЯамнаас зохион байгуулсан “Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн бодлого, 2019 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, хоршоог үнэлэх аргачлал” сэдэвт сургалт, 3-р

сарын 15-нд аймгийн МСҮТ-ээс зохион байгуулсан “Үнэлгээний төлөвлөлт, гүйцэтгэлийн шалгуур тодорхойлох түвшний сургалт”-д худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа зохион байгуулах нөхцлийг сайжруулах нь сэдэвт сургалтанд худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтнүүд хамрагдлаа.

- Сайнцагаан сумын ЗДТГ, МХГ, ХХААГ, БОАЖГ, Цагдаагийн газартай хамтран “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” Засгийн газрын 189 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх сургалтад хамрагдсан 48 иргэд, ААН-ийн төлөөллийг хамруулж мэдээлэл өглөө.
- Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн бизнес эрхлэгч, аж ахуй нэгжүүдийн захирал худалдагч нарт “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хууль, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны үүсэл хөгжил” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгууллаа.
- Шинээр байгуулагдсан болон өргөтгөсөн, нийт үйлдвэр, цехийн судалгаа, Дундговь аймагт шинээр байгуулагдах үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг гаргаж ХХААХҮЯаманд хүргүүллээ.
- Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье аяны төлөвлөгөөг батлуулан сумдад хүргүүлж, Сайнцагаан сумын хоол үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг иргэн ААНэгж байгууллагуудаар явж Хүнсний тухай холбогдох хууль тогтоомж, Хоол үйлдвэрлэлийн газрын Эрүүл ахуйн зохистой дадал /GMP/, стандартын хэрэгжилт зэргийг газар дээр нь үзэж шалган зөвлөмж, мэдээлэл, гарын авлага материалыг тарааж ажилласан.
- МСҮТ-ийн цахилгаан, үсчний ангийн оюутнуудад салбарын холбогдох хууль тогтоомжийн талаар болон стандарт, баталгаажуулалт, цахилгааны аюулгүй байдлын талаар сургалтад 23 оюутныг хамруулж, Монголын үсчин гоо сайханчдын холбоотой хамтарсан үсчин гоо сайханчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, үзүүлэх тоглолтыг зохион байгуулж 18 үсчин гоо сайханчдын мэргэжлийн зэрэг цолыг ахиуллаа.
- Шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа эрхэлж байгаа 15 газарт стандартын баталгаажуулалт явуулж тохирлын гэрчилгээ олгож зөвлөгөө мэдээллээр ханган ажиллалаа.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Байгаль орчны аялал жуулчлал, ашигт малтмал уул уурхайн чиглэлээр:

- Аймгийн ИТХТ-ийн хурлаар түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцүүлж, Гурвансайхан сумын нутагт 12, Өлзийт сумын нутагт 2, Өндөршил сумын нутагт 1 түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох саналыг дэмжсэн тухай тогтоол гаргуулаад байна.
- Гурвансайхан сумын бичил уурхай эрхлэгчид, жонш худалдан авахаар шалгарсан 2 аж ахуйн нэгж, сумын удирдлагуудтай хамтран ажиллах гэрээний талаар уулзалт зохион байгуулан 3 сарын 11-нд гэрээ байгуулж, Баянжаргалан сумын нутагт жоншны ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг “Үнэн-Анд” ХХК-ний 2018 оны хамтран ажиллах гэрээний биелэлтийг тооцож ажиллалаа.
- Аймгийн “Бичил уурхай эрхлэгч хуулийн этгээдийн 2018 оны тайлан”-г бичил уурхай бүхий 4 сумаас авч нэгтгэн Ашигт малтмал газрын тосны газарт хуулийн хугацаанд нь хүргүүллээ.
- Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн газарт 2019 онд хамтран ажиллах гэрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн задаргааны саналыг хүргүүллээ.

- “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” арга хэмжээний хүрээнд байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлах, байгаль орчны багц мэдээ, мэдээлэл хүргэх, олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, “Эко сургууль, цэцэрлэг-2019” болзолт уралдааны нээлтийн арга хэмжээг 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэйгээр 10 сумдад зохион байгууллаа.
- Тус аймгийн Луус сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх улсын чанартай авто замаар нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэж явсан цистерн автомашин 2019 оны 3 дугаар сарын 14-ны өдөр осолдсны улмаас тус газарт их хэмжээний шатахуун асгарч, байгаль орчинд сөрөг нөлөө учирсан тул мэргэжлийн шинжээч томилж, хохирлын хэмжээг тогтоолгож өгөх тухай албан хүсэлтийг аймгийн Цагдаагийн газарт, мөн Луус сумын удирдлагад авч хэрэгжүүлэх ажлын чиглэлийг тус тус хүргүүллээ.
- “Усны менежментийн чадавхийг бэхжүүлэх сургалт”-д байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч нар, сав газрын захиргааны мэргэжилтнүүд, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд оролцож, Мерит төслөөс “Уул уурхай, газрын доорх усны менежмент ба усны хяналт шинжилгээ” сэдэвт сургалтыг сумдын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, Умард говийн гүвээт халхын дундад сав газрын захиргаа зэрэг байгууллагын албан хаагчдад зохион байгууллаа.
- 2019 оны 3 дугаар сарын 28.29-ний өдөр зохион байгуулагдсан Монголын геологи хайгуул 2019 чуулга уулзалтанд ХОХБТХ-ийн дарга, БОАЖ, ашигт малтмал, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн нар оролцлоо.

Дэд бүтцийн чиглэлээр:

- Канад улсын MERIT төслийн хүрээнд 3 дугаар сарын 20-нд Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулагдсан “Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт ба хяналт шинжилгээ, үнэлгээ: Шалгуур үзүүлэлт боловсруулах нь” сэдэвт сургалтанд хэлтсийн ахлах мэргэжилтэн хамрагдаж, БХБЯ-аас 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан Барилга байгууламжийг паспортжуулах сургалтанд Барилга хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн, ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнүүд оролцлоо.
- 2019 оны 2 дугаар сарын 28-нд Үндэсний хөгжлийн газар, МУИС-ын эдийн засгийн хүрээлэн, Үндэсний статистикийн газрын хамтран зохион байгуулсан. “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэгт ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Эрдэнэбаяр, ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга А.Амарбал, МУИС-ын эдийн засгийн хүрээлэнгийн судалгааны зөвлөхүүд, Аймгийн удирдлагууд, агентлагийн дарга нарын нийт 70 гаруй албан хаагчид оролцож Монгол улсын эдийн засгийн бүсчлэлд Төвийн бүсийн өмнөд дэд бүсийн гүйцэтгэх үүрэг, Орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, байршил, Уул уурхай, хүнд үйлдвэр, Эрчим хүч, Зам тээвэр, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбаруудын хөгжил, байршлын төлөвлөлтийн талаарх илтгэлүүдийг сонсож илтгэлтэй холбогдсон хэлэлцүүлэг өрнүүллээ.
- 3 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд “Тогтвортой амьжиргаа-3” төслийн чадавх бэхжүүлэх “Орон нутгийн хөгжлийн санг иргэдийн оролцоотой төлөвлөх”, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээ болон тэргүүлэх чиглэлээр эрэмбэлэх” сэдвүүдээр зохион байгуулсан сургалтанд хөрөнгө оруулалт хариуцсан 2 мэргэжилтэн хамрагдлаа.
- ХОХБТХ-ийн дарга БЗӨБЦТС ТӨХК, Дундговь ЦТССалбарын удирдлагуудтай хамтран аймгийн төвийн багуудын иргэд хөдөлмөрчидтэй уулзалт хийж аймгийн төвд шинээр баригдах дулааны станц барьж ашиглах төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгийн танилцуулга, нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулан, аймгийн Засаг дарга О.Бат-

Эрдэнэ, Засаг даргын орлогч Ж.Мөнхчулуун, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Эрдэнэ-Очир, Гайя консалтингийн захирал Ли Ын Ёи, “КЭСС” олон улсын зөвлөх компанийн гүйцэтгэх захирал Хан Жан Воон, байгаль орчны хэлтсийн захирал Гүн Чин Шин, “Эко трейд” ХХК-ийн үнэлгээний ахлах мэргэжилтэн А. Алтанхуяг, ТЭЗҮ боловсруулсан “KDHEC” компанийн барилгын инженер Ли Жон Ёонг нар болон иргэдийн төлөөлөл оролцож асуулт хариулт явагдаж шинээр баригдах дулааны станцын хүчин чадал, зуухны технологи, шатаах нүүрсний илчлэг, чийг, гарч байгаа үнсийг юунд ашиглах, ус дулаан дамжуулах 8 төвийг нэмэх талаар санал солилцов.

ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн дараах тайлангуудад хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайланг ЗГХЭГ-т хүргүүллээ.
- Аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнийн 2018 онд 15 яамны сайдтай гэрээ байгуулсан гэрээний хэрэгжилт.
- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.7-г үндэслэн 6.3-т заасан аргачлалын дагуу явцын хяналт шинжилгээ хийхэд эхний хагас жилийн байдлаар 68 хувийн хэрэгжилттэй байсан бол жилийн эцсийн байдлаар 90.4 хувийн хэрэгжилттэй болж 22.4 хувиар ахисан үзүүлэлттэй гарсан. Үүнээс нийт 572 заалтаас 100 хувь- 399 заалт, 70 хувь-123 заалт, 30 хувь-12 заалт, 0 хувьтай буюу тасарсан 6 заалт, хугацаа болоогүй 2 байна.
- Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах талаар зохион байгуулсан ажлыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын хавсралт “Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу хэрэгжилтийг нэгтгэн гаргаж хяналт шинжилгээ хийж ажиллалаа.

Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дүнгийн товчоо

№	Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь					Нийт хэрэгжилтийн хувь
			100	70	30	0	ҮБ	
1	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	9	8	1				96,6
2	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	5	4	1				94
	Дүн	14	12	2				95,3

3. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

№	Агуулга	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь	Дундаж
1	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад,	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	11 удаагийн сургалтыг ажлын байран дээр зохион байгуулсан.	100	100
		Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	Нийт 40 албан хаагчид давхардсан тоогоор 215 удаа	100	

	дотоодын сургалт			нийт албан хаагчдын 86,9% нь сургалтад хамрагдсан байна.		
		Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	Гадаад сургалт, арга хэмжээнд 20 хүн буюу нийт албан хаагчдын 43,4 % хамрагдсан байна.	100	
2	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	Мэргэшсэн албан хаагчдын эзлэх хувь 91,3% байна.	100	100
Хэсгийн дундаж:						100
3	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	Дээд газрын шагналд-8, байгууллагын шагналд-3, үр дүнгийн урамшуулалд-40 албан хаагч хамрагдсан. Давхардсан тоогоор 51 хамрагдсан	100	100
		Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, үр чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	2018 онд давхардсан тоогоор 73 албан хаагч нэмэгдэл авч байна. Нийт албан хаагчийн 95,6% нь 2-3 төрлийн нэмэгдэл хөлс авсан байна.	100	
4	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	Сэтгэл ханамжийн судалгааны дүн 73% ба албан хаагчдаас гарсан саналыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг 83,3% хангаж ажилласан.	70	85

		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	2018 онд албан хаагчдын хоолны зардал нэг хүний сард 80.000 төгрөгөөр тооцон 38,067,900 төгрөг олгосон байна.	100	
5	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Жилд 1 удаа албан хаагч хамрагдсан.	100	85
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	34 албан хаагч буюу 73,9% нь хамрагдсан байна.	70	
Хэсгийн дундаж:						90
Үнэлгээний дундаж хувь:			95 %			

- Дундговь аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт шинжилгээг хийж, 2017 оны үзүүлэлт, 2018 оны зорилтот түвшинтэй харьцуулж, Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолын батлагдсан журмын дагуу тооцож дүгнэлээ.

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн дүнгийн товчоо

№	Шалгуур үзүүлэлт	Тоо	Хэрэгжилт					Нийт хэрэгжилтийн хувь
			100	70	40	0	ҮБ	
1	Үзүүлэлтүүд (зорилтот түвшинтэй харьцуулахад)	30	23	7	-	-	-	94
2	Үзүүлэлтүүд (2017 онтой харьцуулахад)	30	23	7	-	-	-	94
	Дүн	30	23	7	-	-	-	94

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны тайланд ЗГХЭГ-аас хяналт шинжилгээ үнэлгээ хийгээд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 98,4 хувьтай, аймгийн хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 97 хувьтайгаар хэрэгжүүлсэн тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн.
- Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх төрийн албан хаагчдыг чадавхжуулах үүднээс Улсын бүртгэлийн хэлтэс, Мал эмнэлэгийн газрын төрийн албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх талаар сургалт мэдээлэл хийж арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

НАЙМ. СУМ, ОР НУТГИЙН ТАЛААР

- **Адаацаг сум:** Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг гүйцэтгэхээр “Инженер геодези” ХХК тендерт шалгаран хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний талаарх эхний шатны хэлэлцүүлгийг иргэдийн дунд зохион зохион байгуулж, хэлэлцүүлэгт нийт 62 иргэн хамрагдсан.
- **Говь-Угтаал сум:** Сумын эмэгтэйчүүдийн 2-р чуулганыг 2019 оны 3 дугаар сарын 7-ний өдөр сумын Засаг дарга, сумын эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран зохион байгуулж 231 эмэгтэй оролцлоо

- **Дэлгэрцогт сум:**Хаврын тэргүүн сарын шинийн 29-ний билэгт сайн өдөр 2019.03.05-нд нутгийнхаа гол шүтээн сахиус “БАЛДАН ЛХАМ” сахиусаа тахиуллаа.
- **Дэрэн сум:** Шороон гахай жилийн сар шинийн золголтыг Дундговь аймаг дахь нутгийн зөвлөлийн ЗДТГ хамтран зохион байгуулж, тус сумын уугуул 50 гаруй иргэд оролцон. сумын ЗДТГ-аас 80-с дээш настай ахмадуудад гарын бэлэг гардууллаа.
- **Өлзийт сум:** Өлзийт сумын малын им, тамга” номын 2 дахь дугаарт шинээр нэмэгдсэн малчин өрхийн малын им тамгыг оруулан нийт 431 өрхийн 450 ширхэг номыг хэвлүүлж багийн Засаг дарга нараар дамжуулан малчдад хүргэлээ.
- **Өндөршил сум:** 2019 оны 3 дугаар сарын 13”ний өдөр Улаанбаатар хотод Өндөршил нутгийн адуугаа омог болгон батлуулах судалгааны ажлын тайлан хэлэлцүүлж 100%-ын саналаар МАА-н салбарын эрдмийн зөвлөлөөр дэмжигдлээ
- **Цагаандэлгэр сум:** Сумын төрийн байгууллагуудын удирдлагууд, төрийн албан хаагчид "Авилгагүй шударга нийгмийн төлөө хамтдаа" уриалгад нэгдлээ.

ЕС. ЦАГ ҮЕИЙН АЖИЛ БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛ

- 2019.03.21-нд ЗГХЭГ-аас зохион байгуулсан цахим хуралд аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ, ЗДТГ-ын дарга Ц.Эрдэнэсүрэн, ТЗУХ-ийн дарга М.Цогзолмаа, хэвлэл мэдээллийн ажилтнууд, ХХААГ, ОБГ-ыг төлөөллүүд оролцож, цаг үеийн ажлууд болон орон нутагт тулгамдсан асуудлын талаар санал солилцлоо.
- 2019.03.22-нд “Нарны охид”төслийн нээлт, өсвөр насны охидын хөгжил хамгааллын зөвлөгөөн боллоо.
- 2019.03.28-нд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлийн дохиогоор ажиллаа.